


БАТЛАВ:

“ХӨТӨЛ ЭНЕРЖИ ДУЛААН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ 
Х.МОӨНХБАЯР

2023 оны 12 дугаар сарын “19”-ны өдөр



Баримтын төрөл: Ажлын даалгавар

Баримтын нэр: Байгаль орчинд нөлөөлөх байдлын болон биологийн олон янз байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажлын даалгавар

1. Зорилго:

Хөтөл энержи дулаан ХХК-ийн дулааны станцын үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангуудад тодотгол хийж байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, болон бусад бичиг баримт, холбогдох хууль, журмын дагуу БОННҮ тайлан, төлөвлөгөө боловсруулах.

2. Хамрах хүрээ:

2.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ.

Дулааны станцын орчимд байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд дараахь объектуудыг хамруулан тодотгол хийх,

- Дулааны станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тодотгож нэгдсэн тайлан боловсруулах
- Станцын үйл ажиллагаатай шууд холбоотой болон дулаан үйлдвэрлэлтийн явцад ашиглагдах түр болон байнгын барилга байгууламж, дэд бүтэц. Үүнд:
 - Дулаан үйлдвэрлэх байр
 - Нуурсний талбай
 - Түлш дамжуулах хэсэг
 - Хяналтын өрөө
 - Лаборатори
 - Дулаан хуваарилах төв
 - Үнс зайлцуулах талбай
 - Ахуян хог хаягдын цэг
 - Дулааны станцын хашаа
 - Яндангийн орчин
 - Технологийн зам
 - Болон бусад

2.2. Биологийн олон янз байдлын судалгаа

Шуеуу: Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд сонгосон 0.5-1км нэг трансектийн дагуу

3. Хийгдэх ажлууд, үе шатууд:

3.1. Урьдчилсан судалгаа үнэлгээ:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

3.2. Судалгааны шат:

- Төсөл хэрэгжих орчны суурь нөхцөл байдал болон байгаль орчны хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлох үүднээс ус, хөрс, агаар, ургамал, амьтны асуудлаар судалгаа хийх, дүгнэлт гаргах,
- Биологийн олон янз байдлын судалгаа
 - Шувуудын тооллого судалгаа /Aves/

- Ургамлын аймаг, ургамалжилтын судалгаа
 - o Ургамлын бүлгэмдлийн зураг боловсруулах
 - o Ургамлын зүйлийн бүрдэл, тархалт
- Байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээний үр дүн:
 - Хөрсний: хими-физикийн, агро-химийн, хүнд метал
 - Усны: гүний усны чанар ба гүний түвшин
 - Агаарын: бохирдол, нийт тоос, нарийн тоос /pm10/

3.3. БОННҮ дунд хугацааны тайлан:

Төслийн техник, технологи, химийн болон биологийн бодис, түүхий эд, туслах материал, завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал, нийгмийн асуудлын талаар судалгаа хийх

- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгаа, түүнийг арилгах арга хэмжээний зөвлөмж. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах талаар авах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ.
- Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах. TNC / олон улсын стандарт/ аргачлалд үндэслэн станцын, нөлөөллийн эх үүсвэрийг /НЭҮ/-г зуухны тоног төхөөрөмжийн насны төлөв байдлаар тооцож дүйцүүлэн хамгаалах газар нутгийн хувилбаруудыг тодорхойлон сонгож холбогдох байгууллагуудаар албажуулах,
- Байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайландаа тусгах;

3.4. Эцсийн тайлан (тайлангийн төсөл):

- Дунд хугацааны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник технологи, тоног төхөөрөмж, хөрөнгө зардал, боловсон хүчиний тооцоог төлөвлөх;
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, төлөвлөгөө БОННҮ – г төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

4. Тайлангийн агуулга

Төслийн товч тодорхойлолт:

Төслийн хүчин чадал, техник технологи, тоног төхөөрөмж, ордын ашиглах дараалал, станцын барилга байгууламж, үйлдвэрлэлийн барилга байгууламж, төслийн эцсийн бүтээгдэхүүн, түүхий эд туслах материал, хог хаягдал, үйлдвэрлэлийн туслах материал, ус хангамж, нүүрс дамжуулах хэсгийн хүчин чадал, технологи

- Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдал, үнэлгээ

Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд, төслийн төлөвлөлтөнд авч үзэх уур амьсгалын хүчин зүйлс, байгалийн бүрэлдэхүүн /биологи, агаар, ус, геологийн тогтоц, газрын гадарга г.м/ тус бүрт нөлөөлөх байдлын үнэлгээ, төслийн талбайн цацрагийн түвшин.

- Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ
- Төслийн болзошгүй болон сөрөг нөлөөллүүд

- Төслийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн менежмент
- Биологийн олон янз байдлын судалгаа

Судалгааны үр дүн:

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө.

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх аргачлал, хяналтын цэгүүдийн байршлыг тогтоох арга зүй. Дараагийн 5 жилийн хэмжилт шинжилгээний үзүүлэлт, давтамж. Шаардлагатай багаж төхөөрөмж үзүүлэлт, тоо ширхэг, лаборатори.

5. Үр дүн, стандарт:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг монгол хэл дээр ирүүлэх бөгөөд ажлын даалгавар болон төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтээр тогтоосон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх чиглэл-хуваарийн дагуу, техникийн шинжтэй, алдаагүй, шууд хуулбарлаагүй, үнэн бодит мэдээлэлд тулгуурласан судалгаанд үндэслэсэн байна:
- Станцын объект тус бүрийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг боловсруулж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОМ төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгана.
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын судалгаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мониторинг судалгааны арга зүйг ашиглана.
- Биологийн олон янз байдлын судалгааны тайлан дараах стандартын дагуу бичигдэж, доор дурдсан мэдээллийг тусгасан байна: Үүнд:
 - Гүйцэтгэгч нь өгөгдсөн ажлыг гүйцэтгэх судалгааны /нэг/ аргазүйг санал болгох ба тухайн аргазүйг гүйцэтгэх чадвартайгаа зөвхөн өмнө хийгдсэн ажлын туршлагаар батална. Олон улсын банк, санхүүгийн байгууллагын (IFC) биологийн олон янз байдлыг хамгаалах шаардлага, стандарт (Performance Standard 6) аргазүйн дагуу гүйцэтгэг нь давуу тал болно. - Судалгааны бүсэд өмнө хийгдэж байсан судалгааны хураангуй, тойм
 - Трансект, цэгүүд, тооллогын аргыг заасан талбайн амьтдын тоо толгойг төлөөлөх байдлаар сонгох
 - Бүс нутгийн амьтан, ургамалын аймгийн (ангилал зүйн нэршил, түгээмэл амьтан, ургамлын төлөөллийн гэрэл зураг) тойм
 - Төслийн талбай орчмын амьтны ангилал зүйн бүлэг, зүйл тус бүрийн ажиглалтын байршил, трансект, тоо толгойн мэдээ, ховордлын төлөв байдал, нягтшил, экологийн үнэ цэнэ
 - Судалгааны тоймыг (трансект, маршрут, ажиглалтын дүн, объект, дэд бүтэц) тусгасан судалгааны талбайн байр зүйн зураг (1:10000), GIS мэдээллийн багц тус тус хамрагдна.
- Сөрөг нөлөөллийн үнэлгээ нь бодит тооцоонд тулгуурласан байна. Бохирдуулагчийн хэмжээг тооцоходоо уур амьсгалын онцлог, хөрсний шинж чанар, хэмжилт шинжилгээний мэдээний дүн, станц бүрэн хүчин чадлаараа ажиллах үеийн тоног төхөөрөмжийн тоо, технологийн процесст үндэслэнэ.

- Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдлын жагсаалтыг гаргаж нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр, устгах арга хэлбэрийн хувилбаруудыг оруулна
- Хог хаягдлын менежментийн хүрээнд удирдлага зохион байгуулалтыг төлөвлөх, хог хаягдлыг зайлцуулах байршил, дахин боловсруулах арга хэлбэр, хувилбаруудыг оруулна

Талбайгаас дээж авах тоо, байршууд нь төслийн байгаль орчинд нөлөөлөх серөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн байгаль орчны төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төслийг боловсруулахад шаардагдах суурь мэдээ баримт болон ашиглагдахуйц байна.

- Орчны төлөв байдлын суурь мэдээлэл нь олон жилийн мэдээ баримтаас гадна хамгийн сүүлийн үеийн мэдээ баримтыг агуулна
- Хаалтын төлөвлөгөөг дулаан үйлдвэрлэлттэй зэрэгцэн нөхөн сэргээлт хийхэд үндэслэн сонирхогч талууд саналыг тусган, санал гомдлын механизм байгуулах, хаалтын нөхөн сэргээлтийн сан байгуулах, биотехникийн нөхөн сэргээлт хийх зэрэг хаалтын аргачлалд тусгасан төсөл хэрэгжүүлэгчийн авах шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар тодорхойлж тусгана.
- Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ тус бүрт хэрэгжүүлэх хувилбаруудыг дэлгэрүүлж дотоодын болон олон улсын практикт мөрдөгддөг шилдэг туршлагуудыг дурьдана.

6. Холбогдох баримт бичиг

- Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар
- Дүйцүүлэн хамгааллын аргачлал. TNC, бус нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайланг боловсруулах журам

7. Гүйцэтгэгчид тавигдах хамгийн бага шаардлага:

- Заавал БОННҮ хийх эрх бүхий аж ахуй нэгж байгуулага байна.
- Биологийн судалгааны ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байхыг заавал шаардахгүй.
- Нийт судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, багаж төхөөрөмжтэй байна.

Хянасан:

Ерөнхий инженер



Б.Цэцэнбилгэг

Боловсруулсан:
ХАБЭА-н инженер



Б.Чулуун-Эрдэнэ